



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 1/89

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 9.000.000 (Есөн сая) төгрөгийн санхүүжилтээр хийгдэж буй "Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх Цоохорын худаг, Шороотын эх, Пагвын овоотын худаг" засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Б.Баттогтох (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

С.Жаргалсайхан (Иргэний төлөөлөл)

2. "Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажил нь ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьж, шаардлагад нийцсэн худгийг хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, бүрдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА М.БАЯРСҮХ